

# ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 8 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДГА-2025/141/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дорноговь аймаг 2025 он	Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор/Аудитор: Б.Алтанцэцэг Утас: 8000-7121 Цахим хаяг: Tolinetugen@gmail.com Аудитор Г.Шүрэнцэцэг Утас: 8905-6740 Цахим хаяг: Tolinetugen@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	12
3.1 Төлбөрийн акт.....	12
3.2 Албан шаардлага .....	12
3.3 Зөвлөмж .....	12
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	13

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гуламж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

2025.02.25 № 1-6/103

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

САЙНШАНД СУМЫН ХҮҮХДИЙН  
8 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ З.ГАНТУУЛ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 8 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн



442502097

асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### **Бусад асуудлын хэсэг**

2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 91.3% хувийн биелэлттэй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд адбоус-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ





## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

КОД	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>127,416,232.49</b>	<b>129,648,797.14</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	61,887,196.49	68,783,011.14
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	61,887,196.49	68,783,011.14
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	61,887,196.49	68,783,011.14
31211	Төрийн сангийн харилцах	61,887,196.49	68,783,011.14
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	65,529,036.00	60,865,786.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	46,931,511.00	44,068,341.00
35110	Тусгай зориулалттай материал	46,900,001.00	43,908,341.00
35130	Эм боох материал	31,510.00	160,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	18,597,525.00	16,797,445.00
35410	Бичиг хэргийн материал	358,300.00	1,648,000.00
35420	Аж ахуйн материал	11,103,235.00	7,721,279.00
35440	Түлш, шатах тослох материал	30,000.00	-
35460	Хүнсний материал	7,105,990.00	7,428,166.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>679,304,125.86</b>	<b>662,489,437.93</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	679,304,125.86	662,489,437.93
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	651,406,809.48	634,937,521.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	731,182,677.17	731,182,677.17
39202	Хуримтлагдсан элэгдэл	(117,318,576.94)	(141,086,374.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	57,211,693.00	50,767,831.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(35,523,669.18)	(29,135,339.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	57,689,652.35	44,162,989.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	(42,794,825.10)	(25,072,620.27)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,855,000.00	4,539,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,392,758.82)	(918,258.90)
39217	Ном	497,617.00	497,617.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	27,897,316.38	27,551,916.30
39301	Програм хангамж	1,727,000.00	1,727,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,237,683.62)	(1,583,083.70)
39303	Бусад биет бус хөрөнгө	27,408,000.00	27,408,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>806,720,358.35</b>	<b>792,138,235.07</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>748,704.40</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	748,704.40
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	748,704.40
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	542,704.40
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	206,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	206,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>806,720,358.35</b>	<b>791,389,530.67</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	806,720,358.35	791,389,530.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	272,831,525.00	272,831,525.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	216,570,568.29	203,314,228.48
51210	Өмнөх үеийн үр дүн	216,570,568.29	218,645,056.16
51220	Тайлант үеийн үр дүн	-	(15,330,827.68)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	317,318,265.06	315,243,777.19
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>806,720,358.35</b>	<b>792,138,235.07</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>497,402,808.35</b>	<b>691,147,650.43</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,072,360.00</b>	<b>16,063,041.51</b>
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,072,360.00	16,063,041.51
Төсөв байгууллагын өөрийн орлого	2,072,360.00	105,000.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		15,958,041.51
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,827,360.00	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	245,000.00	105,000.00
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>495,330,448.35</b>	<b>675,084,608.92</b>
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	443,165,300.00	611,645,700.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	443,165,300.00	611,645,700.00
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	52,165,148.35	63,438,908.92

Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,165,148.35	63,438,908.92
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>487,171,661.63</b>	<b>706,478,478.10</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>487,171,661.63</b>	<b>706,478,478.10</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	486,071,661.63	699,003,978.10
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	302,803,078.00	466,724,980.35
Үндсэн цалин	244,767,561.00	352,814,806.35
Нэмэгдэл	51,184,024.00	103,241,274.00
Урамшуулал	6,851,493.00	10,668,900.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38,834,337.96	58,767,404.40
Тэтгэврийн даатгал	26,911,756.93	40,587,350.04
Тэтгэмжийн даатгал	3,167,917.83	4,800,982.37
ҮОМШӨ-ний даатгал	2,424,334.29	2,367,091.50
Ажилгүйдлийн даатгал	575,484.45	2,202,396.33
Эрүүл мэндийн даатгал	5,754,844.46	8,809,584.16
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	42,265,148.35	50,717,908.92
Гэрэл, цахилгаан	3,708,729.35	4,137,737.92
Түлш, халаалт	32,245,939.00	36,496,691.00
Цэвэр, бохир ус	6,310,480.00	10,083,480.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,259,142.00	14,163,356.00
Бичиг хэрэг	884,700.00	941,300.00
Тээвэр, шатахуун	100,000.00	30,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,694,082.00	4,996,996.00
Бараа материал актальсны зардал	3,580,360.00	8,195,060.00
<b>Нормативт зардал</b>	42,513,656.00	49,238,654.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,990.00	31,510.00
Хоол, хүнс	42,506,666.00	49,207,144.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,890,860.00	14,134,260.00
Урсгал засвар	2,890,860.00	14,134,260.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	615,000.00	1,140,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	615,000.00	1,140,000.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	46,890,439.32	44,117,414.43
Бараа үйлчилгээний бусад зардал	4,571,300.00	3,646,285.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,613,000.00	3,049,500.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,706,139.32	37,421,629.43
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,100,000.00	7,474,500.00
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,100,000.00	7,474,500.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,100,000.00	7,474,500.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>10,231,146.72</b>	<b>(15,330,827.67)</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	0.01
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	0.01
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(0.01)
<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>10,231,146.72</b>	<b>(15,330,827.68)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>495,575,448.35</b>	<b>675,189,608.92</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>245,000.00</b>	<b>105,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	245,000.00	105,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	245,000.00	105,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	245,000.00	105,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>495,330,448.35</b>	<b>675,084,608.92</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	443,165,300.00	611,645,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	443,165,300.00	611,645,700.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	52,165,148.35	63,438,908.92
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,165,148.35	63,438,908.92
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>450,794,664.31</b>	<b>663,644,894.27</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>450,794,664.31</b>	<b>663,644,894.27</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>449,694,664.31</b>	<b>656,170,394.27</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	302,803,078.00	466,621,980.35
210101	Үндсэн цалин	218,131,134.68	316,535,686.38
210102	Нэмэгдэл	78,208,005.43	133,919,908.97
210104	Урамшуулал	6,463,937.89	16,166,385.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38,834,337.96	58,327,700.00
210201	Тэтгэврийн даатгал	27,013,206.30	39,662,900.00

210202	Тэтгэмжийн даатгал	3,043,345.19	4,666,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,381,836.16	2,333,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	581,413.67	2,333,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,814,536.64	9,332,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>42,265,148.35</b>	<b>50,717,908.92</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,708,729.35	4,137,737.92
210302	Түлш, халаалт	32,245,939.00	36,496,691.00
210303	Цэвэр, бохир ус	6,310,480.00	10,083,480.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>44,598,400.00</b>	<b>49,824,020.00</b>
210502	Хоол, хүнс	44,598,400.00	49,824,020.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,900,000.00</b>	<b>12,721,000.00</b>
210604	Урсгал засвар	9,900,000.00	12,721,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>615,000.00</b>	<b>1,300,000.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	615,000.00	1,300,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10,678,700.00</b>	<b>16,657,785.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,105,700.00	10,983,285.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,573,000.00	5,674,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,100,000.00</b>	<b>7,474,500.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,100,000.00</b>	<b>7,474,500.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,100,000.00	7,474,500.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>44,780,784.04</b>	<b>11,544,714.65</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>2,603,000.00</b>	<b>4,648,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,603,000.00</b>	<b>4,648,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,603,000.00</b>	<b>4,648,900.00</b>
222001	Тоног төхөөрөмж	2,603,000.00	3,153,400.00
223001	Бусад хөрөнгө	-	1,495,500.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(2,603,000.00)</b>	<b>(4,648,900.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>42,177,784.04</b>	<b>6,895,814.65</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>61,887,196.49</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>61,887,196.49</b>	<b>68,783,011.14</b>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ	ХУРИМТЛАГДСАН ДҮН	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНИЙ НИЙТ ДҮН
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	272,831,525.00	317,318,265.06	206,339,421.57	796,489,211.63
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>272,831,525.00</b>	<b>317,318,265.06</b>	<b>206,339,421.57</b>	796,489,211.63
Тайлант үеийн үр дүн	-	-	10,231,146.72	10,231,146.72
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>272,831,525.00</b>	<b>317,318,265.06</b>	<b>216,570,568.29</b>	806,720,358.35
<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>272,831,525.00</b>	<b>317,318,265.06</b>	<b>216,570,568.29</b>	806,720,358.35
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,074,487.87	2,074,487.87
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>272,831,525.00</b>	<b>317,318,265.06</b>	<b>218,645,056.16</b>	808,794,846.22
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(2,074,487.87)	-	(2,074,487.87)
Тайлант үеийн үр дүн	-	-	(15,330,827.68)	(15,330,827.68)
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>272,831,525.00</b>	<b>315,243,777.19</b>	<b>203,314,228.48</b>	791,389,530.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	731,772,000.00	668,293,794.27
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	731,772,000.00	668,293,794.27
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	726,097,500.00	660,819,294.27
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	516,809,200.00	466,621,980.35
210101	Үндсэн цалин	367,774,800.00	322,033,171.38
210102	Нэмэгдэл	139,989,400.00	133,919,908.97
210104	Урамшуулал	9,045,000.00	10,668,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	60,344,800.00	58,327,700.00
210201	Тэтгэврийн даатгал	41,035,700.00	39,662,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,826,500.00	4,666,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,413,700.00	2,333,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,413,700.00	2,333,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,655,200.00	9,332,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	53,765,000.00	50,717,908.92
210301	Гэрэл, цахилгаан	6,000,000.00	4,137,737.92
210302	Түлш, халаалт	36,727,700.00	36,496,691.00
210303	Цэвэр, бохир ус	11,037,300.00	10,083,480.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	55,533,200.00	50,824,020.00
210502	Хоол, хүнс	55,533,200.00	50,824,020.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	12,721,000.00	12,721,000.00
210604	Урсгал засвар	12,721,000.00	12,721,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,021,000.00	1,140,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,021,000.00	1,140,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	24,903,300.00	20,466,685.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,228,800.00	14,792,185.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,674,500.00	5,674,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5,674,500.00	7,474,500.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,674,500.00	7,474,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,674,500.00	7,474,500.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	731,772,000.00	675,189,608.92
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	665,181,000.00	611,645,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	611,645,700.00	611,645,700.00
131009	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	53,535,300.00	
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	66,486,000.00	63,438,908.92
132001	Орон нутгийн төсвөөс	66,486,000.00	63,438,908.92
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	105,000.00	105,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.00	105,000.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>61,887,196.49</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>68,783,011.14</b>

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар 898.7 мянган төгрөгийн нийт 2 алдаа зөрчил илэрсэнд зөвлөмж өгч ажилласан.

#### **3.1 Төлбөрийн акт**

2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

#### **3.2 Албан шаардлага**

2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага тогтоогдоогүй болно.

#### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудлаар**

###### Илрүүлэлт:

2024 оны санхүүгийн байдлын тайланд ажилчидтай холбоотой 542.7 мянган төгрөгийн, хувь хүмүүст өгөх 206.0 мянган төгрөгийн, нийт 748.7 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл тайлагнасан байна.

###### Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.заалтыг хэрэгжүүлж өр авлага үүсгэхгүй, төсвийг зохистой удирдаж ажиллах.

##### **2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгт шалгалтын төлбөрт 150.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

###### Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.3.үр ашигтай байх заалтын дагуу төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2024 оны санхүүгийн байдлын тайланд ажилчидтай холбоотой 542.7 мянган төгрөгийн, хувь хүмүүст өгөх 206.0 мянган төгрөгийн, нийт 748.7 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл тайлагнасан байна.	1	748.7					1	748.7		
<b>Нийт</b>	<b>1</b>	<b>748.7</b>	-	-	-	-	<b>1</b>	<b>748.7</b>	-	-

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
<b>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>										
Төсвийг үр ашиггүй зарцуулсан	1	150.0						1	150.0	
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>150.0</b>	-	-	-	-	-	<b>1</b>	<b>150.0</b>	